

Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэн стандартыг тогтоох тухай журмын 10 дугаар хавсралт

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр

Төсвийн ерөнхийлөн захирагч: Аймгийн Засаг дарга

(Хуулийн 6.4.8, 6.8.1 заалтын хүрээнд)

Д/д	Шийдвэр гаргагч	Шийдвэрийн огноо	Шийдвэрийн дугаар	Төрөл/хөрөнгө зарцуулах, өр авлага үүсгэх	Шийдвэрийн хуулбар
1	Аймгийн Засаг дарга	2024.08.01	A/402	Хөрөнгө зарцуулах тухай	
2	Аймгийн Засаг дарга	2024.08.08	A/410	Хөрөнгө зарцуулах тухай	
3	Аймгийн Засаг дарга	2024.08.15	A/422	Хөрөнгө зарцуулах тухай	
4	Аймгийн Засаг дарга	2024.08.15	A/423	Хөрөнгө зарцуулах тухай	
5	Аймгийн Засаг дарга	2024.08.15	A/425	Дэмжлэг үзүүлэх тухай	
6	Аймгийн Засаг дарга	2024.08.22	A/428	Дэмжлэг үзүүлэх тухай	

Төрийн сангийн мэргэжилтэн: Б.Гантулга



Холбогдох утас: 88089938

И-мэйл хаяг: b.gantulga@khs.gov.mn



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/402

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.4 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Терроризмтой тэмцэх зөвлөлийн Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлийн 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хяналт шалгалт хийх, сургалт сурталчилгаа зохион байгуулах үйл ажиллагаанд 3,000,000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 3,000,000 (гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дансны "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны бараа үйлчилгээний бусад зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011209



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/410

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, 4.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Жүдо бөхийн Олон улсын хэмжээний мастер, Дэлхийн 2024 оны аварга, Хөвсгөл аймгийн иргэн Бавуудоржийн Баасанхүү нь "Парис-2024" зуны олимпод жүдо бөхийн төрөлд Монгол улсаа төлөөлөн оролцож олимпын мөнгөн медаль авсанд баяр хүргэж 2 өрөө байраар шагнасугай.

2. Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 7-р баг 7676-4 байр 5 давхар 35 тоот хаягт байршилтай 48,4 м.кв талбай, 2 өрөө орон сууцны зардалд 125,840,000 (Нэг зуун хорин таван сая найман зуун дөчин мянга) төгрөгийг зарцуулсугай.

3. Дээрх зардлын 125,840,000 (Нэг зуун хорин таван сая найман зуун дөчин мянган) төгрөгийг аймгийн "Засаг даргын Тамгын газрын биеийн тамирын спорт дэмжих хөтөлбөрийн нийтийн биеийн тамирын зардал"-аас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011240



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/422

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 20 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны 07 дугаар сарын 11-ны өдөр хүчтэй аадар бороо, үер орсны улмаас Мөрөн сумын 13 дугаар хорооны зарим айлын хашаанд орсон лаг шаврыг цэвэрлэх зардалд шаардлагатай 3,000,000 (Гурван сая) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 3,000,000 (Гурван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712011271



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/423

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 4.1, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 08 дугаар сарын 15-ний өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд Ойн дагалт баялаг, хууль бус ан агнуур, Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, Малын шилжилт хөдөлгөөнийг хянах зэрэг хяналт шалгалтын ажилд ажиллах албан хаагчдын шатахуун болон хоолны зардалд 7,680,000 (долоон сая зургаан зуун наян мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3.Авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоонд Ойн дагалт баялаг, хууль бус ан агнуур, Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх, Малын шилжилт хөдөлгөөнийг хянах зэрэг хяналт шалгалтын ажлыг удирдан зохион байгуулж, тайлагнан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал)-т даалгасугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М. Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011274



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 15 өдөр

Дугаар А/425

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 20 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Спортын уралдаан тэмцээнд оролцох, эрүүл мэндийн чиглэлээр эмчилгээ хийлгэх, бусад дэмжлэг тусламж хүссэн иргэдэд олгох мөнгөн дэмжлэгийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлын 6,700,000 (Зургаан сая долоон зуун мянга) төгрөгийг аймгийн “Засаг даргын нөөц хөрөнгө”-өөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011275



Аймгийн Засаг даргын 2024 оны
08 сарын 15-ны өдрийн
А/Ч.ЗХ.захирамжийн хавсралт

/төгрөгөөр/

ДД	Ирсэн өргөдөл, хүсэлтийн утга, тайлбар	Шийдвэрлэх мөнгөн дүн
1	Мөрөн сумын 2 дугаар багийн иргэн Ц.Отгонбаяр ам бүл 1, нөхөр нь олон жилийн өмнө нас барсан, тэтгэвэрээс өөр орлоггүй, биеийн байдал дордож эмчилгээ хийлгэдэг болсон тул дэмжлэг хүссэн	300,000
2	15 настай Л.Түвшинбаяр тархины ясны хорт хавдартай болсон, Солонгост 430.0 сая төгрөгийн хагалгаа хийлгэх болсон тул дэмжлэг хүссэн. Эмээ Оюун-Эрдэнэ	1000,000
3	Тэтгэвэрээс өөр орлоггүй, өөрийн гэсэн гэр орон газаргүй, өндөр настай ээжийгээ асарч хүндхэн амьдарч байгаа тул газар, гэр, мөнгөн дэмжлэг хүссэн. Иргэн Г.Алтанцэцэг	300,000
4	Х.Хишигт 95 настай, өөрийн гэр оронгүй айл айлаар амьдарч байна, биеийн байдал дордож эмчилгээ их хийлгэдэг болсон тул дэмжлэг хүссэн	500,000
5	Харааны бэрхшээлтэй, оюутан бөгөөд нүдэндээ протез суулгасан, эмчилгээ хийлгэх шаардлагатай байгаа тул санхүүгийн дэмжлэг хүссэн, Мөрөн сумын 4 дүгээр багийн иргэн Э.Түмэнхүү	300,000
6	Элэгний хорт хавдар оноштой болсон, хот орж эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон тул дэмжлэг хүссэн Ц.Балжинням	300,000
7	6 дугаар ангийн сурагч Ц.Эрхэс олимпын таэквондогоор хичээллэдэг. Улс аймгийн хэмжээнд олон өндөр амжилт үзүүлж байгаа. Солонгос улсад болох олон улсын тэмцээнүүдэд оролцох болсон тул дэмжлэг хүссэн Н.Дэлгэрмаа	500,000
8	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтны өдөр, ахмад ажилтан Ц.Нямдоржын алдрыг тэмдэглэх өнгөрүүлэх зардалд дэмжлэг хүссэн	500,000
9	2024 оны 10 сард Хорватын Порец хотод болох мастеруудын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох 3 тамирчин замын зардалд дэмжлэг хүссэн иргэн Х.Алтанбагана, О.Баатархүү, Д.Баярдалай	1500,000
10	Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдаж байгаа 21 аймгийн аварга шалгаруулах хөл бөмбөгийн тэмцээн Сүхбаатар аймагт болох тул санхүүгийн дэмжлэг хүссэн Холбооны дэд дарга Л.Энхболд	1000,000
11	Өмнөд Африкт болох олон улсын шүүгчдийн их хуралд Монгол улсаа төлөөлөн оролцох Хөвсгөл аймгийн шүүхийн шүүгч Л.Эрдэнэбатад зардлын дэмжлэг хүссэн Шүүгчийн холбоо Т.Туяа	500,000
	Дүн	6700,000



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 22 өдөр

Дугаар А/428

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баясгалан овогтой Энхжинд (РЮ06300705) Улаанбаатар хотын Монгол Олон Улсын дээд сургуулийн 2024-2025 оны хичээлийн жилд бакалаврын ангид элсэн суралцахад дотуур байр болон хоолны зардалд 2,600,000 (хоёр сая зургаан зуун мянга) дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлын 2,600,000 (хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

6712011286